

**МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН,  
АРДЫН УРЛАГ СУДЛАГЧ, ЯРУУ НАЙРАГЧ  
Ж.БАДРААГИЙН 80 НАСНЫ ОЙД**

*Ч.Батцэцэг\**

Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн, ардын урлаг судлагч, яруу найрагч Ж.Бадраагийн 80 насны ой 2006 оны 3-р сард тохиох гэж байна.

Ж.Бадраа нь 1926 оны 3 дугаар сарын 21-нд Хөвсгөл аймгийн Бүрэнхаан суманд төрсөн. 1941 онд 15 настайдаа Хөвсгөлийн Мөрөн төвийн 7 жилийн сургуульд элсэн суралцаж 1944 онд төгсгөөд, Улаанбаатар хотноо Багшийн сургуульд шилжиж хоёр жил суралцан тоо, бодосзүйн багшийн мэргэжил эзэмшин төгсгөмөгц 1946 онд Улсын их сургуулийн багш нарын факультетийн хэл бичиг утга зохиолын ангид элсэн суралцаж 1950 онд төгсгөсөн. 1950-1952 он хүртэл Хөвсгөл аймгийн 10 жилийн дунд сургуульд хэл бичиг, утга зохиолын багш, хичээлийн эрхлэгчээр ажиллаж байгаад 1952 онд нийслэлд дуудагдан ирж Улсын радио хороонд орж, 1958 он хүртэл ажиллахдаа техник уран сайхны хэлтсийн дарга, хөгжим уран сайхны нэвтрүүлгийн редакцийн эрхлэгч, радиогийн дуу найруулагч зэрэг алба хашиж байв. 1958 онд Энэтхэг улсын Дели хотноо явж Энэтхэгийн соёлыг судлах олон улсын хүрээлэнд хинд, санскрит хэлний чиглэлээр суралцсан. 1959 онд Ховд аймагт багшаар томилогдон ажилласан.

Түүнээс хойш Улаанбаатар төмөр замын удирдах газар орчуулагч, Энх тайван найрамдлын гүйцэтгэх хороонд “Зөвлөлт Холбоот Улс” сэтгүүлийн монгол хэвлэлийн орчуулагч, эрхлэгч (1960-1963), Улсын кино үйлдвэрт орчуулгын киноны редактораар ажиллах завсраа Дуурь бүжгийн театрын дэргэдэх дуурийн дуучдын сургуульд “Дуулахын үг хэлний ур зүй”, “Дэлхийн хөгжмийн түүх” хичээл зааж байжээ (1963-1967).

Улсын их сургуулийн хэл-зохиолын факультетэд 1967-1973 он хүртэл багшаар ажиллахдаа “Монгол хэлний найруулга зүй”, “Орчуулгын онол”, “Дорнодахины утга зохиол”, “Монголын судлалын удирдхал” зэрэг хичээл зааж байсан. 1973 оноос Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх, Шинжлэх Ухаан Техник Мэдээллийн Төвд мэргэжилтнээр, 1976 оноос Монголын Хөгжмийн Зохиолчдын Холбоо, Монголын Урлагийн ажилтны Холбоонд ажилласан. 1989 оноос Монгол Ардын Урлагийн “Хуур магнай” Өм Төвийн Ерөнхий захирагчаар ажиллаж байгаад 1993 оны 8 дугаар сарын 3-нд насан өөд болжээ.

Тэрээр монгол хэл найруулга, ардын урлаг, хөгжим судлал, орчуулга, яруу найргийн чиглэлээр голчлон судлан шинжилж туурвин

\* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

бүгээж байсан бөгөөд түүний бүтээлийн арвин өв сан, соёл урлаг, төр нийгмийн салбар дахь зүдхэл үйлсийг тоймлон товчоолвоос:

- “Халуун элгэн нутаг минь” (ая.Ц.Намсрайжав), “Сүлд модны наадмын дуу”, “Жаргаах зүрхэн” (ая. С.Гончигсумлаа), “Охидын уянга”, (ая. Д.Лувсаншарав), “Зандан шоо”, “Намрын шөнө” (ая. Г.Бирваа), “Чандмань эрдэнэ”, “Аргалд явсан эжий” (ая. Н.Жанцанноров), “Орь залуу нас” (ая. Т.Насанбуян), “Уяхан хорвоон хань” (ая. С.Чойсүрэн), “Гайхмаараа” (ая. З.Батсүх) зэрэг олонд түгэн дэлгэрсэн 400 орчим дууны шүлэг бичиг “Уяхан хорвоон хань”, “Чандмань эрдэнэ” гэсэн дууны түүвэр гаргасан бөгөөд “Халуун элгэн нутаг минь” дуунд нь Нийслэл хотноо хөшөө босгосон нь анхдагч болсон.

Орос хэлнээс А.С.Пушкиний “Евгений Онегин”, “Лусын дагина” дуурь, (Дуурь Бүжгийн Улсын Театр нээлтээ хийхдээ анх /1963-5-30/ гаргасан), “Энэтхэг цэцэн үгс”— самгарди хэлнээс, Хардялалүсинхийн “Шагүндалаа” (Гаалидаасын жүжгийн хураангуй)-хиндии хэлнээс, Равиндранаат Таагүр “Өргөлийн дуулал” (128 дуулал шүлэг)-хиндии хэлнээс, Пүччиний “Тоска” дуурь-итали хэлнээс, А.Власов, А.Млодик нарын “Хөх цэгцгийн бүх цэрэг”, Ю.Германы “Итгээч над та минь” кино, Василий Шукшиний “Ийм нэгэн залуу байдаг” кино, “Байлдагчийн эцэг” кино- орос хэлнээс орчуулсны зэрэгцээ олон арван өгүүлэл, шүлэг, дуурийн ари, ном товхимол орчуулсан.

- “Монголын дуу хөгжимд халдсан нэгэн хүнийг тахин шүтсэний хор хөнөөл хийгээд түүнээс ангижрах зам”- дэлгэрэнгүй илтгэл, “Манай анхны симфони”-Л.Мөрдоржийн “Эх орон” симфонийг судалсан шүүмж өгүүлэл зэрэг хөгжмийн шүүмж, судалгааны өгүүлэл, илтгэл, гарын авлага; “Орчин үеийн орчуулгын ном хэвлэл, үг ярианы найруулгын тухай, “Хайран сайхан монгол хэл минь”, “Дөрвөн “ба” минийх биш”, “Үгийн тайлбар”, “Монгол хэлний найруулга зүйн наад захын шаардлага” зэрэг хэл, найруулга зүйн шүүмж, судалгааны бүтээл; “Ардын уран бүтээл судлах арга зүйн асуудал”, “Монголын хөгжмийн түүхээс”, “Ардын урлаг”, “Ардын хөгжим”, “Утга төгөлдөр уртын дуу” зэрэг ардын урлаг, дуу хөгжмийн холбогдолтой шүүмж судалгааны өгүүлэл зэрэг нийт 100 дөхсөн байна.

“Монгол ардын хөгжим”, “Хөгжмийн нэр томъёоны толь” нэг сэдэвт судалгааны бүтээл нь өнөө үед судалгааны гарын авлага болж байна. Олон улсын ардын урлагийн “Радуга” теле наадамд түүний зохиолоор хийсэн “Монгол хөөмэй”, “Ингэн эгшиг”, “Цацал” кинонууд 3 удаа дараалан тэргүүн байр эзэлж, “Уртын дуу” кино тусгай шагнал хүртэж байсан. Тэр үеийн 18 аймагт бүгдэнд нь явж нутаг нутгийн үндэстэн ястны дуу хөгжим, уран бүтээлийг сурвалжлан судалж теле-

радио цуврал нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлж байсан нь телевиз радиогийн фондод хадгалагдаж байх ёстой.

Монгол Ардын Урлагийн “Хуур магнай” өм төвийг “Эртний сайхан” ахмадын чуулга, “Түмэн эх” чуулгын бүрэлдэхүүнтэй байгуулан, ардын урлагийг судлах, сургах, сурталчлах үйлсийг үүсгэсэн. МУИС-ийн Монгол Хэл Соёлын Сургуулийн Ардын урлаг судлалын тэнхим санаачлан байгуулсан.

АНУ, ЗХУ, Герман, Энэтхэг, Умарт Солонгос, Болгар, Өзбег улсад зорчиж, хурал, симпозиум, илтгэл тавих, лекц унших, ардын дуу бүжгийн хамтлаг ахлан аялан тоглох зэргээр эх орон, улс үндэстнээ сурталчилж иржээ. Олон улсын хөгжим судлагчдын чуулга уулзалт, хурал, индэрт (Самарканд 1978, Пеньяан 1983) **“Уртын дуу, хөөмэй, морин хуур монголын уламжлалт мэргэжлийн сонгодог хөгжимийн хосгүй хэв маяг”** гэдгийг баталсан илтгэл тавьж байсныг үндэслэн өнөөдөр ЮНЕСКО-ийн соёлын өвийн бүртгэлд оржээ.

“Цагаан сарын шинийн нэгэн”, “Миний улаан ном”, “Ардаан дээдлэх улирал ирвэй”, “Үзэх сонсохын соёл”, “Мандухай цэцэн хатан” киноны учир зэрэг өгүүлдээ нийгмийн сэтгэлгээний шинэчлэлд уриалж, өөрийн улс үндэстний түүх соёл, уламжлалыг эрхэмлэх, тухайлбал цагаан сарыг зөвхөн малчин ардын баяр бус, нийт ард түмний баяр болгохыг уриалан санаачилж байсан, мал нийгэмчилснээр нүүдлийн мал аж ахуй, малчин ардын амьжиргаа доройтон итгэл алдарсаныг шүүмжлэн хэрхэх тухайд санал дэвшүүлж байлаа.

Төрийн бэлэг тэмдэг, ёслолыг шинэчлэхэд санаа оноо, зөвлөгөө биечлэн өгч, Мэгжид Жанрайсаг Бурхан бүтээх их үйлсийг санаачлагчийн нэг байсны зэрэгцээ “Мандухай цэцэн хатан”, “Мөнх тэнгэрийн хүчин дор” кинонд зөвлөхөөр ажиллаж байв.

1951 онд Хөвсгөл аймгийн Зүрх сумын 226 дугаар тойргоос Улсын Их Хурлын депутатаар, 1956 онд Улаанбаатар хотын Чойбалсангийн хорооны депутатаар сонгогдож байсан. МАХН, Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, Монголын Үйлдвэрчний Эвлэл, Монголын Хөгжмийн Зохиолчдын Холбоо, Монголын Зохиолчдын Эвлэл, Монголын Урлагийн Ажилтны Холбооны гишүүн, Монгол-Оросын Найрамдал Нийгэмлэгийн гишүүн, Монгол-Энэтхэгийн Найрамдал Нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн бөлгөө.

Ж.Бадраа нь улс үндэстнийхээ соёлын өв уламжлалыг олон улсын тавцанд хүлээн зөвшөөрүүлж хойч үедээ үлдээх, олон улсын эв нэгдлийг бэхжүүлэх, соёлын гадаад харилцааг хөгжүүлэхэд асар их хувь нэмэр оруулж, эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө амьдрал, цаг заваа зориулсан монголын соён гэгээрүүлэгч, нийгмийн зүтгэлтэн, тэргүүний сэхээтэн, ардын дипломатч хүн байсан юм.